

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.020.10

Ойн аж ахуйн байгууллагад байгаль орчны менежмент (удирдлага)-ийн тогтолцооны ISO 14001, ISO 14004 стандартыг хэрэглэхэд туслах мэдээлэл	MNS ISO/TR 14061:2002
Information to assist forestry organizations in the use of Environmental Management System standards ISO 14001 and ISO 14004	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төвийн Зөвлөлийн 2002 оны 2 дугаар сарын-ны өдрийн-р тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2002 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандарт нь зөвлөмжийн шинжтэй байна.

1. Хамрах хүрээ

Энэ техникийн тайланг ISO 14001, ISO 14004 стандартыг хамтатган хэрэглэх зорилгоор боловсруулсан. Энэ нь ойн аж ахуйн байгууллагад чухал ач холбогдолтой ОТХУ-ын зарчим, Засгийн газар хоорондын шалгуур, заагч бүхий ойн удирдлагын гүйцэтгэлийн зорилго, ойн бодлого болон ISO 14001-ын удирдлагын тогтолцооны хандлагын хоорондын холбоогоор хангана. Мөн олон улсын ISO 14000 бүлэг стандартын шаардлага, ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, ойн байгууллагад ач холбогдолтой байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх бусад арга хэмжээгээр хангана.

Энэ техникийн тайлан нь ISO 14001-д заасан шиг ойн аж ахуйд тавигдах онцгой шаардлагыг тодорхойлохгүй. Үүний агуулга нь норматив биш, мэдээллийн шинжтэй байна. Гэсэн хэдий ч ойн удирдлагын гүйцэтгэлийн түвшинг тогтоохгүй. Энэ тайлан нь байгаль орчны гүйцэтгэлийн шаардлагын үндсэн хэлбэр болж чадахгүй ба бүтээгдэхүүний эко-тэмдгийг бий болгохгүй.

2. Нэр томъёо ба тодорхойлолт

Энэ техникийн тайлангийн зорилгын дагуу ISO 14050-д заасан нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

2.1. Байгаль орчны асуудал

Байгаль орчинтой харьцах тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг

Тайлбар: Байгаль орчинд хор уршигтай асуудал гэдэг нь түүнд хортойгоор нөлөөлж буй эсвэл нөлөөлж болзошгүй байгаль орчны асуудал.

2.2. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс шалтгаалан байгаль орчинд үзүүлэх эерэг ба сөрөг (хэсэгчилсэн буюу бүхэлдээ) өөрчлөлт

2.3. Байгаль орчны удирдлагын тогтолцоо

Байгаль орчны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хангах, дүн шинжилгээ хийхэд чиглэсэн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны төлөвлөлт, үүрэг, туршлага, журам, үйл явц болон нөөцийн асуудлыг багтаасан удирдлагын ерөнхий тогтолцооны хэсэг

Тайлбар: Энэ техникийн тайлангийн зорилгын дагуу байгаль орчны удирдлагын тогтолцоог ISO 14001 стандартад тайлбарласан байдлаар ашиглана.

2.4. Ой

Мод, бусад модлог ургамал, түүний хөрс, ургамал, амьтан, тэдгээрийн харилцаа холбоо, нөөц баялаг

Тайлбар:

Ой нь дэлхий дахины уур амьсгал, хөрс, хөгжингүй орнуудын түүх соёлоос хамаарч маш их өөрчлөгдөж байна. Олон улс орон хууль тогтоомжиндоо ойн тухай заасан байна.

2.5. Байгууллага

Өөрийн үйл ажиллагаа, удирдлагатай улсын буюу хувийн компани, нэгтгэл, пүүс, үйлдвэр, аж ахуйн нэгж, эрх бүхий байгууллага буюу алба эсвэл тэдгээрийн хослол

Тайлбар:

Нэг эсвэл түүнээс олон үйл ажиллагааны нэгжийг байгууллагын хэмжээнд авч үзэж болно.

2.6. Зарчим, шалгуур, заагч

ОТХУ-д хүрэхэд чиглэсэн үйл явцыг үнэлэхэд зориулсан "Зарчим, шалгуур, заагч"-ийг багтаасан шатлан захирах хүрээний харилцаагаар хангах, засгийн газрын эсвэл засгийн газрын бус байгууллага, олон улсын, үндэсний хувийн хэвшлийн санаачлага

Тайлбар 1: Зарим санаачлаганд зарчмыг шалгуурт багтсан байна.

Тайлбар 2: Энэ тайлангийн зорилгын дагуу шалгуур, заагч гэсэн нэр томъёог засгийн газар хоорондын үйл явцын дүнд хэрэгжүүлсэн ОТХУ-ын шалгуур ба заагчийн шаардлагад зааснаар онцгойлон ашиглана.

2.6.1. Зарчим

Шалтгаан болон үйл ажиллагааний тохирох үндсэн үүрэг

Тайлбар:

Зарчим нь ОТХУ болон зорилгын тодорхой бүрэлдэхүүн хэсэг

2.6.2. Шалгуур

Чухал ач холбогдолтой үзүүлэлт ба үүгээр ололт, дутагдлыг үнэлнэ.

Тайлбар:

Шалгуурын үүрэг нь ОТХУ-ын үнэлэх үйл явц, нөхцөл байдал, энгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох, үзүүлэх юм.

[Арга хэмжээ: ОТУ-ын шалгуур, заагчийн засгийн газар хоорондын семинар]

2.6.3 Заагч

Үечилсэн байдлаар үнэлсэн, хянасан өөрчлөлтийг хянахад гарах тоо хэмжээ, чанар эсвэл үзүүлэх арга хэмжээ

[Арга хэмжээ: ОТХУ-ын шалгуур, заагчийн засгийн газар хоорондын семинар]

2.7. Тогтвортой хөгжил

Ирээдүй үеийнхэний хэрэгцээнд тохирсон тэдэнд хор учруулахгүй бөгөөд одоогийн хэрэгцээнд нийцэх хөгжил

[Арга хэмжээ: Брундландын баримт бичиг]

2.8. Ойн тогтвортой хөгжлийн удирдлага

Тайлбар:

ОТХУ гэсэн ойлголт нь удирдлагын хэлэлцээр бөгөөд янз бүрийн үндэстэн, олон улсын санаачлагаар хөгжүүлсэн тодорхойлолт нь янз бүр байна. Дэлхийн өөр өөр бүс нутгийн хүмүүсийн тодорхойлсон ОТХУ-ын тухай 2 тодорхойлолтыг энэ техникийн тайланд үзүүлсэн.

2.8.1. Ойн тогтвортой хөгжлийн удирдлага

Байгаль орчин, хүн болон нийгэмд үзүүлэх тохиромжгүй нөлөөгүй, түүний ач холбогдол, цаашид бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бууруулахгүй ойн бүтээгдэхүүн үйлчилгээний байнгын урсгалын бүтээмжтэй холбоотой удирдлагын нэг эсвэл түүнээс олон тодорхойлсон зорилгод хүрэх ойн хөрсийг тогтмол удирдах үйл явц.

[Арга хэмжээ: Олон улсын Халуун орны модны байгууллага (ОУХОМБ)]

2.8.2. Ойн тогтвортой хөгжлийн удирдлага

Бусад эко-тогтолцоонд хор нөлөөгүй орон нутаг, үндэсний болон дэлхийн түвшинд экологи, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаатай холбоотой байх өнөө үед болон ирээдүйд биологийн төрөл зүйл, бүтээгдэхүүн, түүний дахин сэргэх байдал, амьдрах чадвар, тэдгээрийн чадавхийг тогтоох замаар ой болон ойн хөрсийг ашиглах, үйлчилгээ

[Арга хэмжээ: Европын үйл явц]

3. ISO 14000-ын бүлэг стандарт

3.1. Ерөнхий

110 гаруй үндэсний стандартын байгууллага, олон улсын холбогдох байгууллагыг нэгтгэсэн олон улсын стандартын байгууллага нь дэлхий дахины засгийн газрын бус байгууллагаар 1946 онд байгуулагдсан. Энэ байгууллагын зорилго нь олон улсын харилцаа холбоо, нэгдлийг сайжруулах, олон улсын зах зээлийн өсөлт, түүний зохицуулалтыг дэмжихийн тулд олон улсын стандартыг хэрэгжүүлнэ. Олон улсын бүх стандарт нь нээлттэй ба зохицуулалтын шинжтэй, тэдгээрийн хэрэгжилт нь зөвлөмжийн шинжтэй байна.

Өнөө үед олон улсын ISO 14000 бүлэг стандарт нь байгаль орчны удирдлагын тогтолцоо, байгаль орчны аудит, амьдралын мөчлөгийн үнэлгээ, байгаль орчны эко-тэмдэг, байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ явуулахад чиглэнэ. Олон улсын эдгээр стандартыг

ойн аж ахуйн байгууллагад хэрэгжүүлнэ. Эдгээр стандартын нэмэлт дөрвөн мэдээллийг (ISO 14001, ISO 14004-ын бусад) А хавсралтад үзүүлсэн.

3.2. Байгаль орчны удирдлагын ISO 14001 ба ISO 14004 стандарт

Байгаль орчны удирдлагын тогтолцоо нь байгууллагын үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөх асуудал болон холбогдох үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд чиглүүлнэ. Энэ нь байгууллагын байгаль орчны асуудал болон хамаарах нөлөө, түүний хууль зүйн болон бусад шаардлагын тухай мэдлэгд үндэслэж удирдах боломж олгоно. Үүнийг сонирхогч талуудын дүн шинжилгээг нэгтгэх, нөөц баялаг, сургалт, үүрэг хариуцлагын хуваарилалт, явуулах үнэлгээ, туршлага, журам, үйл явцын сайжруулалтын үндсэн дээр хийнэ.

Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001, Байгаль орчны удирдлагын тогтолцоо- Ерөнхий шаардлага, ашиглах удирдамж, ISO 14004, Байгаль орчны удирдлагын тогтолцоо – Зарчим, арга ажиллагааны ерөнхий заавар гэсэн 2 стандарт байна.

ISO 14001 нь олон улсын чанар хангах ISO 9001, ISO 9002, ISO 9003 стандарттай удирдлагын тогтолцооны зарчмийг нийцүүлнэ. ISO 14001-ын тодорхойлолт нь Төлөвлө-Хий-Шалга-Ажилла (1-р зураг) гэсэн зарчимд үндэслэх БОУТ-ны шаардагдах бүрэлдэхүүн хэсгийг үзүүлж, түүгээр хангах ба үүнд байнгын сайжруулалт хийнэ. Байгууллага ISO 14001-ыг дотоод зорилгодоо болон стандарттай нийцэх өөрийн зарласан мэдүүлэгт ашиглана. ISO 14001 нь тусгай 3 дахь талын аудитын дагуу баталгаажуулах байгууллагын БОУТ-той холбоотой ISO 14000 бүлэг стандартын зөвхөн нэг стандарт.

ISO 14004-ын заавар нь байгаль орчны удирдлагын тогтолцоог багтаасан нэмэлт шалтгаанаар хангах ба тогтолцоог сайжруулахыг хүссэн эсвэл БОУТ-гүй байгууллагад ашигтай байна.

ISO 14004-ын заавар нь тодорхойлсон баримт бичиг биш бөгөөд аудит болон баталгаажуулалтын зорилгоор ашиглахад хамаарахгүй. Гэсэн хэдий ч, энэ нь ISO 14001-ын шаардлагын дагуу ажиллах байгууллагад ашигтай.



1-р зураг - ISO 14001:1998 стандартын байгаль орчны удирдлагын тогтолцооны загвар

4. Ойн аж ахуйн байгууллагад шаардагдах материал

4.1. Ерөнхий

Энэ бүлэгт заасан шаардагдах материал нь ISO 14001-ын бодлого, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтэд ОТХУ-ыг нэгтгэхэд ойн аж ахуйн байгууллагад тусална. Нийгэм, эдийн засаг, экологийн асуудал бүхий ОТХУ-ын асуудал нь дээрхи хоёр шийдвэрийг үе шаттай хэрэгжүүлж, дэлхий, бүс нутаг, үндэстэн, үндэстэн хоорондын төвшинд ойлголтыг чиглүүлнэ. В хавсралтад заасан шаардагдах материал нь тэдгээр байгууллагад ашиглах ойн удирдлаг зориулсан бодлогын хүрээнд мэдээллээр хангана. В хавсралтаар ойн тусгай талбайд зориулан ашиглах мэдээлэлд дэлхий нийтийн болон засгийн газар хоорондын ойн аж ахуйн талаархи санаачлагаас гарах арга хэмжээний хүрээнд энэ мэдээллийг үзүүлсэн.

4.2. Засгийн газар хоорондын санаачлага

Байгалийн нөөц баялгийн тогтвортой хөгжлийн удирдлага болон байгаль орчны асуудалд чиглэсэн үндэстэн хоорондын олон чухал хэлэлцээрийн

хэрэгжүүлж байна. Байгаль орчны талаархи хөдөлгөөн өрнөж, 1980 онд Дэлхий Хамгаалах Стратегийн нийтлэл, 1987 онд Байгаль орчин, хөгжлийн чуулган хуралдаж "Бид бүхний ирээдүй" уриатай Брундландын тайлан гарсан. 1992 оны 6-р сард Зүүн Самматад болсон "Ойн тухай зарчим" болон "Agenda 21" гэсэн асуудал бүхий БОХОУЧ (UNCED)-аар ойн аж ахуйн тухай хэлэлцсэн. Эдгээр баримт бичигт дэлхийн ойн тогтвортой хөгжлийн удирдлагын тухай ойлголт багтана. Тогтвортой хөгжлийн олон улсын чуулган (ТХОУЧ) (UNCSD) нь "Agenda 21"-ийн хэрэгжилтийг дэмжих зорилготой. Ойн засгийн газар хоорондын комисс (ОЗГХК) 1995 онд байгуулагдсан. Үүний үйл ажиллагааний нэг нь ОТХУ-ын экологи, эдийн засаг, нийгмийн асуудалд шалгуур ба заагчийг хэрэгжүүлэхэд олон улсын харилцааны таатай нөхцөл болсон. 1997 онд ОЗГХК нь ажлаа олон улсын хэмжээнд тайлагнасан ба шинэ Засгийн газар хоорондын ойн чуулган (ЗГХОЧ)-аар үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн явуулсан. ЗГХОЧ нь ажлаа 2000 онд тайлагнасан.

Эдгээр санаачлагын нэг хэсэг, засгийн газар хоорондын үйл явц нь үндэсний төвшинд ойн нөхцөл байдлын чиг хандлагыг үнэлэхэд ашиглах ОТУ-ын шалгуур ба заагчийг хэрэгжүүлнэ. Засгийн газар хоорондын шалгуур, заагчийн үйл явцыг В хавсралтын жагсаалтад харьцуулан жагсааж, нарийвчлан гаргасан байна:

- Олон улсын халуун орны модны байгууллага

- Пан-Европ (Хелсинки)-ын үйл явц

- Монтреалын үйл явц

- Тарапотогийн төлөвлөгөө

- Хуурай бүсийн Африкийн санаачлага

- Хойд ба өмнөд Африкийн санаачлага

- Төв Африкийн Лепатерикийн санаачлага

- Африкийн ойн байгууллагын санаачлага

Шалгуур нь ойн тогтвортой удирдлагын чухал бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлдог бол заагч нь ойн бодит нөхцөл байдлыг үнэлнэ. Үндэсний онцгой зорилгод нэгтгэх үед Засгийн газар хоорондын шалгуур, заагчийг ОТХУ-д чиглэсэн үйл явцыг үнэлгээгээр хангана. Иймээс шалгуур, заагч нь хэрэгжүүлэлтийн үр дүнг үнэлэх, ойн үндэсний хөтөлбөр, бодлогын зорилгыг тогтооход чухал үүрэгтэй.

Ихэнх засгийн газар хоорондын санаачлага дараахь ойн аж ахуйн асуудалд чиглэх шалгуур ба заагчийг багтаана:

Ойн нөөцийн хэмжээ

Эрүүл мэнд, амьдрах чадвар

Үр ашигтай ажиллагаа.

Биологийн төрөл зүйл

Байгаль орчны үйл ажиллагаа ба сэргийлэх

Хөгжил дэвшил ба нийгмийн хэрэгцээ

Хууль зүй, бодлого, судалгааны хамрах хүрээ

[Арга хэмжээ: Засгийн газар хоорондын ойн комисс]

Ойн тогтвортой хөгжлийн удирдлагын экологи, эдийн засаг, нийгмийн асуудлын хоорондын харилцаа холбоог Пан-Европын үйл явцын хөгжүүлсэн шалгуур, заагчаар тодорхойлж, жишээг 2-р зурагт үзүүлсэн.

Зарим оронд үндэстний хэмжээнд ойн тусгай талбайн түвшинд ашиглах заагчийг тохируулж, тодорхойлж, сайжруулах ба шалгуурыг шийдвэрлэнэ. Засгийн газар хоорондын сайжруулсан шалгуур, заагч нь ОТХУ-ын зорилгод нийцэх бодлого, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтийг тогтооход ач холбогдолтой байгууллагын байгаль орчны чухал асуудлыг бүс нутгийн төвшинд тогтооход илүү ашигтай байна.

4.3. Засгийн газрын бус санаачлага

Засгийн газрын бус байгууллага ойн сайн удирдлагын зарчим, шалгуур, заагчийг хэрэгжүүлнэ. Эдгээр байгууллагад ой эзэмшигч, ойн бүтээгдэхүүний зах зээлийн харилцагч, байгаль орчны холбогдох бүлэглэл, бусад олон зүйл багтана. Олон улсын, Ойн Үйлчилгээний Зөвлөл (ОУЗ) нь 10 зарчмыг хэрэгжүүлсэн ба энэ нь ойн тусгай газрын түвшинд ашиглах болон ойн стандартын нарийвчилсан үнэлгээний "Сайн удирдсан ой"-д зориулсан шалгууртай холбоотой байсан. Олон улсын болон үндэсний төвшинд ойн үйлдвэрлэл, худалдааны нийгэмлэг ойн удирдлагын заавар "Журам"-ыг хэрэгжүүлсэн. Мөн, Олон улсын ойн аж ахуйн судалгааны төв (ОУОААСТ) нь ОТХУ-ын янз бүрийн засгийн газар хоорондын шалгуурыг туршиж, үнэлдэг ба эдгээрийг янз бүрийн байгууллагад хэрэгжүүлсэн. Бүс нутгийн иргэн, харилцааны бүлэглэл нь ойн удирдлагад чиглэсэн ойн тухай бодлого, зарчмыг хэрэгжүүлнэ.

Засгийн газрын бус бүх санаачлага нь ойн аж ахуйд байгаль орчны бодлого, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтийг хэрэгжүүлэхэд хэрэглэх сонирхогч талуудын дүн шинжилгээний тухай чухал мэдээллээр хангана. Эдгээр санаачлагыг В хавсралтаар илүү нарийвчлан тайл-

барласан.



2-р зураг – ОТХУ-ын Пан-Европын шалгуур, заагч

5. Ойн аж ахуйн байгууллагын байгаль орчны менежмент (удирдлага)-ийн тогтолцоо, ОТХУ-ын зарчим, Засгийн газар хоорондын шалгуур, заагч (индикатор)-ийн хоорондын уялдаа холбоо

5.1. Ерөнхий зүйл

Энэ бүлэг нь БОУТ-нд үндэслэсэн ISO 14001-ын бүрэлдэхүүн хэсэг болон засгийн газар хоорондын шалгуур, заагч, ОТХУ-ын зарчмийг багтаасан ойн гүйцэтгэлийн арга хэмжээний хоорондын харилцаа холбооны тухай мэдээллээр хангана. Засгийн газар хоорондын шалгуур, заагч болон зарчмийг нэгтгэж (В хавсралт) ОТХУ-ын зорилгодоо хэрэглэх байгууллага БОУТ-ны хүрээнд тэдгээрийн бодлого, зорилго, төлөвлөгөөт үзүүлэлтийг ашиглахыг хүсдэг. ОТХУ-ын зарчим, засгийн газар хоорондын шалгуур, заагч нь тусгай ойн гүйцэтгэлийн шаардлага болон эдгээрт яаж хүрэхийг тогтоохгүй. Эдгээр нь үндэсний түвшинд тогтвортой байдалд хүрэхэд чиглэсэн улс орны үйл явцыг үнэлэх харилцаагаар хангана. Иймээс, тэд байгууллагын БОУТ-ны зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтэд бүс

нутгийн нөхцөлийг хамруулж шийдвэрлэнэ. БОУТ-ны зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлт, тусгай ойн удирдлагын гүйцэтгэлийн шалгуурын хоорондын хамаарал нь ойн аж ахуйн байгууллагын ОТХУ-ын зорилгод чиглэсэн ойн удирдлагыг сайжруулдаг.

Ойн аж ахуйн зарчим болон засгийн газар хоорондын шалгуур, заагчийн уялдаа болон ISO 14001-ын шаардлагыг 3-р зурагт үзүүлэв.

Тэдгээрийн харилцааны талаархи илүү тодорхой жишээг D, E, G, H, I хавсралтаар үзүүлсэн.

Олон улсын янз бүрийн ОТХУ-ын зарчим, Засгийн газар хоорондын шалгуур, заагч нь В хавсралтаар үзүүлсэн шиг ойн төрөл, уур амьсгалын бүсийн хоорондын ялгаанд төвлөрнө. Жишээ нь: Монреалын шалгуур, заагчийн үйл явц, Амазоны сав газрын халуун орны модыг хамгаалах Таралотогийн төлөвлөгөө.

Ойн төрлийн хооронд үүсэх бусад чухал ялгааг ОТХУ-ын засгийн газар хоорондын шалгуур, заагчийг хэрэгжүүлэхэд ашиглах ба чухал нөлөөтэй байна. Жишээлбэл, ойн удирдлагыг эрчимжүүлэх, ойг ашиглах нь нөөц талбайд болон тариалангийн талбай бүхий эрчимтэй сайн удирдсан ойгоос үргэлжлэнэ. Тэдгээрийн төрөл зүйл, удирдлагын зорилго, эзэмшигчдийн бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг ойн олон янзын категори нь дэлхийн дахины бохирдлыг хангана. Байгаль, шалгуурын хэрэгжүүлэлт, заагч нь янз бүр байна.

Бодлого, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтэд хамаарах ОТХУ-д хүрэх, түүнийг хэрэгжүүлэх ойн эдгээр янз бүрийн категори нь тогтвортой хөгжлийн ерөнхий зорилгод нийцнэ.

5.2. Ойн аж ахуйн байгууллагад хэрэгжүүлсэн байгаль орчны удирдлагын тогтолцооны хамрах хүрээ


ISO 14001 нь БОУТ-ны хамрах хүрээг тодорхой тогтоохыг шаарддаг (ISO 14001-ын 1-р бүлгийг үз). Ойн аж ахуйн салбар нь янз бүрийн ажиллагаа, бизнесийн нэгж, газар зүйн байрлалын цогц болно. Эдгээр ажиллагаанд ургац хураах, мод тээвэрлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаа багтана. Ойн аж ахуйн байгууллага нь тэдгээр ажиллагаанд бүхэлд нь нөлөөлж эсвэл хяналт тавьж чадахгүй иймээс БОУТ-ны хамрах хүрээнд багтах түүний хандлагыг тодорхойлох хэрэгтэй.

Энэ техникийн тайланд ойн аж ахуйн байгууллагын нөөцийн удирдлагын ажиллагаанд онцгой шаардлагатай материалыг үзүүлнэ. Эдгээрийг сайжруулж болно: мод бэлтгэх, зам байгууламж, уугуул нутгийн удирдлага, биологийн төрөл зүйлийн удирдлага, жуулчлал, амралтын хэрэгцээ.

Ойн аж ахуйн байгууллагад бүтээгдэхүүн үүсэх ойн хөрсийг хянах түвшин янз бүр байна. Зарим тохиолдолд, байгууллага тэдгээрийг яаж удирдахаа тодорхойлж, хөрсөнд хяналт тавих, эзэмшиж болно. Бусад тохиолдолд ойн аж ахуйн байгууллага нь уурхай, тос нэрэх, хөдөө аж ахуй, усан цахилгааны эх үүсвэр, ойгоос модноос өөр бүтээгдэхүүн бэлтгэх байгууллагатай хамтран ажилладаг шигээ нэг, түүнээс олон үйл ажиллагаа бүхий ойн талбайг хамтарч ашиглаж болно. Бусад ашиглагчдын эрх, хэрэгцээ нь байгууллагын удирдлагын тогтолцооны хүрээнд чухал ач холбогдолтой. Удирдлагын гэрээ, зөвшөөрлийн үндсэн дээр бусад байгууллага хөрсийг хариуцлагатай хамтран эзэмшиж болно. Өнөөг хүртэл бусад байгууллага нээлттэй зах зээлд модыг нэмэгдүүлэх чадвар, түүхий эд материалын эх үүсвэрийн талаар бага мэдлэгтэй байна. Ихэнх тохиолдолд, байгууллага нийлүүлэгч, гэрээлэгчийн шаардлага, холбогдох журмыг харилцан мэдээлж, тэдгээрийн зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлттэй танилцах хэрэгтэй.

Бусад талуудад нөлөөлж болох ойн аж ахуйн байгууллагын БОУТ, үйл ажиллагаа, ажиллагааны жишээг доор үзүүлсэн:

- а) Харилцан холбоотой нийлүүлэгч, гэрээлэгчийн тогтоох мод бэлтгэлийн тогтолцооны үнэлгээ
- в) Байгаль орчны талаархи боловсрол, сургалтыг сайжруулах хөтөлбөрийн харилцаа холбооны хэрэгжүүлэлт
- с) Нийлүүлэгч, гэрээлэгчийн бодлого, зорилгын дэмжлэг



3-р зураг – ISO 14001-ын хүрээнд Засгийн газар хоорондын шалгуур, заагч болон ОТХУ-ын зарчмын хэрэгжүүлэлт

ТАЙЛБАР 3-р зурагт ойн аж ахуйн байгууллагад ач холбогдолтой шалгуур, заагч, ОТХУ-ын зарчим бүхий ойн удирдлагын бодлогын материалын хамрах хүрээ, ISO 14001-ын удирдлагын тогтолцооны чиг хандлагын хоорондын боломжит холбоог үзүүлсэн.

Баруун талын хэсэгт ISO 14001-ын үндсэн бүрэлдэхүүн хэсгийг үзүүлсэн.

Зүүн талын хэсэгт ОТХУ-ын ойлголтод хамаарах зарим чухал бүрэлдэхүүн хэсгийг үзүүлсэн. Сумнууд нь тэдгээр ОТХУ-ын бүрэлдэхүүн хэсэг, БОУТ-ны ISO 14001-ын бүрэлдэхүүн хэсэг болон хамаарах шаардлагын хоорондын боломжит холбоог үзүүлсэн. 5-р бүлэгт 2 хэсгийн хоорондын боломжит холбоог тайлбарласан.

ISO 14001 нь БОУТ-ны хамрах хүрээг тогтооход байгууллагыг уян хатан байдлаар хангах ба байгууллагад болон тусгай ажиллагааны нэгжид стандартыг хэрэгжүүлж, сонгоно. БОУТ-ны хамрах хүрээний талаар илүү их мэдээлэл авах байгууллага ISO 14001:1996 стандартын 1-р зүйл болон А хавсралтыг үзнэ үү.

5.3. Бодлого

ISO 14001 нь байгаль орчны бодлогод байгууллагын хүлээн зөвшөөрөх байгаль орчны хууль тогтоомж бусад шаардлагатай холбоотой үүрэг түүнчлэн байнгын сайжруулалт, урьдчилан сэргийлэх ажиллагаа багтаасан байхыг шаарддаг.

(ISO 14001:1996, 4.2)

В хавсралтад 1992 онд Рио Де Жанейрод болсон НҮБОХЧ (UNCED)-ны хуралдаанаас хойш хэрэгжүүлсэн янз бүрийн бодлогын баримт бичгийг жагсааж үзүүлэв. Эдгээрт ойн зарчим, олон улсын, засгийн газрын, засгийн газрын бус янз бүрийн байгууллагын ОТУ-ын зарчим, шалгуур, заагч багтана. Эдгээр засгийн газар хоорондын шалгуур, заагчийг хууль тогтоомж, практикийн зөвлөмжийн хууль, бусад засгийн газрын бус байгууллагын стандартад багтаасан байх ба үндэсний болон тусгай ойн газар нутгийн түвшинд тодорхойлно.

Үүний дүнд В хавсралтад үзүүлсэн мэдээлэл нь ISO 14001 БОУТ-ны бодлого, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтийг дараахь замаар нэгтгэнэ:

А) хууль тогтоомжтой нийцэх үүргийн хэсэг

- Б) хүлээн зөвшөөрөх бусад шаардлагатай нийцэх үүргийн хэсэг
- В) сонирхогч талуудын үзэл бодлын харилцааны үр дүн

5.4. Төлөвлөх

5.4.1. Ерөнхий зүйл

Төлөвлөлт нь БОУТ-ны дараах бүрэлдэхүүн хэсэгт хамаатай: Байгаль орчны асуудал, хууль тогтоомж, бусад шаардлага, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлт болон байгаль орчны удирдлагын хөтөлбөр (ISO 14001:1996, 4.3)

5.4.2. Байгаль орчны асуудал

ISO 14001 нь байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчны асуудлыг тогтоож, байгаль орчинд сөрөг нөлөөтэй эсвэл ашиг тустай эсэхийг тодорхойлохыг шаарддаг. Эдгээр чухал асуудалд байгууллагын журам, байгаль орчны зорилгыг хослуулан авч үзнэ. БОУТ-ны хамрах хүрээнд байгаль орчны асуудлаас гадна байгууллагын хяналт, нөлөөлөл багтана (ISO 14001:1996, 4.3.1).

Байгаль орчинд сөрөг нөлөөлөх асуудал болон ойн аж ахуйн байгууллагад онцгой нөлөөлөх зөрим жишээг доор үзүүлсэн:

- А) ургац хураах – ойн цар хүрээ, онцгой найрлага, амьдрах орчинд гарах өөрчлөлт
- В) эмийн бэлдмэл бэлтгэх талбай – хөрсний нөхцөл, хөрс хамгаалалд гарах өөрчлөлт
- С) зам байгууламж – усны төвшин, загасний нутагшил, усны хоолойн бүтцэд гарах өөрчлөлт
- Д) ойгүй болох – онцгой найрлага, төрөл зүйлд гарах өөрчлөлт

В хавсралтад ойн аж ахуйн байгууллагын байгаль орчинд сөрөг нөлөөлөх асуудлыг тогтооход туслах тайлбарыг үзүүлсэн.

5.4.3. Хууль зүйн ба бусад шаардлага

ISO 14001 нь байгууллагад хууль тогтоомж болон бусад шаардлагыг хэрэглэхийг шаарддаг (ISO 14001:1996, 4.3.2).

Ойн удирдлагын хууль тогтоомж, бусад шаардлага, зөвшөөрөл болон засгийн газрын бодлогын нэгдэл, хамрах хүрээ нь улс орнуудад өөр өөр байна. Ердийн шаардлагад дараах арга хэмжээ хамаарна:

- а) ус, хөрс, агаарын чанар
- б) загас, байгаль, тэдгээрийн уугуул нутаг

- c) ховор ургамал, ан амьтан
- d) ойн түймэр
- e) хортон ба өвчин үүсгэгч
- f) газар нутгийн өв соёл
- g) химийн бодисын хэрэглээ

5.4.4. Байгаль орчны зорилго ба экологийн төлөвлөгөөт үзүүлэлт

ISO 14001 нь байгууллагын ажиллагааны байгаль орчны чухал асуудлыг тооцох, байгаль орчны бодлоготой нийцэх байгаль орчны зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтийг тогтоохыг шаарддаг (4-р зургийг үз). Байгууллагын зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, тогтооход хууль зүйн болон бусад шаардлага, байгаль орчны чухал асуудал, технологи, санхүү, үйл ажиллагааны болон бизнесийн шаардлага, сонирхогч талуудын үзэл бодол ач холбогдолтой (ISO 14001:1996, 4.3.3).



4-р зураг – Зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтийг ашигласан шалгуур

ISO 14001 нь байгаль орчны төлөвлөгөөт үзүүлэлтийг байгаль орчны зорилгод хүрэхэд чиглэсэн, тогтоосон хэрэгцээ, нарийвчилсан гүйцэтгэлийн шаардлагаар тодорхойлно. Эдгээр байгаль орчны төлөвлөгөөт үзүүлэлт нь дотооддоо хэрэгжүүлсэн зарчим, шалгуурт үндэслэх ба тусгай ойн талбайд хэрэгжүүлэх заагчийг ашиглана.

Засгийн газар хоорондын шалгуур, заагчийг ашигласнаар сонирхогч талуудаас үүрэг хариуцлага шаардах болно. Олон улсын харилцаа нь бүс нутгийн шалгуур, заагч болон гүйцэтгэлийн шаардлагыг тогтооход олон нийтийн оролцоог чухалчлан авч үзэх тогтвортой ойн аж ахуйд чиглэнэ. Ойн тогтвортой удирдлагад ой эзэмшигч, удирдлагад үйлчлэгчид, сонирхогч талууд болон дараахь харилцаа багтана: ойн аж ахуйн ажиллагсад, орон нутгийн хүмүүс, эрдэмтэд, байгаль орчны бүлэглэл, ойтой хамаатай харилцаа, ойн бүтээгдэхүүнийг хэрэглэгч, засгийн газрын агентлаг, санхүүгийн байгууллага, амралтын бүлэг, ойн орчим амьдрах хүмүүс.

5.4.5. Байгаль орчны удирдлагын хөтөлбөр

ISO 14001 нь байгууллагын зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтэд хүрэх хөтөлбөрийг тогтоохыг шаарддаг (ISO 14001:1996, 4.3.4).

5.5. Хэрэгжүүлэлт ба ажиллагаа

ISO 14001 нь байгууллагын байгаль орчны бодлого, зорилго, төлөвлөгөөт үзүүлэлт, хяналтын журам, хөтөлбөрт хялбар аргаар хүрэх, хэрэгжүүлэх арга хэмжээний журмыг хэрэглэхийг шаарддаг (ISO 14001:1996, 4.4).

5.6. Шалгах ба засварлах ажиллагаа

ISO 14001 нь байгууллагын хяналт, арга хэмжээ авах, үл тохирлын судалгаа хийх, засварлах, сэргийлэх ажиллагаа түүнчлэн БОУТ-ны аудитын тайлан, түүнийг явуулах журмыг тогтоохыг шаарддаг.

5.6.1. Хяналт тавих ба арга хэмжээ авах

ISO 14001 нь байгууллагын бодлого, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлтэд нийцэх байгаль орчинд сөрөг нөлөөлөх түүний үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд арга хэмжээ авах, хяналт тавихийг шаарддаг (ISO 14001:1996, 4.5.1). Хяналт тавих болон арга хэмжээ авахад ОТХУ-ын заагч, хамаарах шаардлагатай холбоотой гүйцэтгэлийн арга хэмжээг багтаана.

Байгалийн нөөцийн удирдлагын асуудал багтаасан ойн аж ахуйн байгууллагын ажиллагаа болон үйл ажиллагаанд хяналт тавьж, арга хэмжээ авна.

Жишээ нь:

- a) ойн амьд, идэвхтэй харилцаа
- b) ойн нөөц, ажиллагааны ялгаа, газар зүйн хэмжээ

- c) хяналт тавьсан нөөцийн найрлага (ж нь: биологийн төрөл зүйл, амьд байгаль, ойн өсөлт, хөрс, усны чанар)
- d) 50 жилээс илүү цаг хугацааны давтамжийг төлөвлөх
- e) янз бүрийн төрөл болон ой ашиглах
- f) газар эзэмших, түүний тогтолцоо

Эдгээр бүх асуудлын тодорхойлсон зорилго, төлөвлөгөөт үзүүлэлтэд холбоотой ажиллагааны гүйцэтгэлд арга хэмжээ авах, хяналт тавихад маргаантай асуудал гарч болно. Ялангуяа, газарзүйн байрлал, янз бүрийн байгальтай ойн аж ахуйн байгууллагын үүрэг хариуцлага, үйл ажиллагааны чиг хандлага нь зорилго, төлөвлөгөөт үзүүлэлтэд хүрэх хөтөлбөрийг хянахад нөлөөлнө. ISO 14031 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ (БОНБГҮ)-ний стандарт нь байгаль орчны зорилго, төлөвлөгөөт үзүүлэлт, бусад БОНБГ-ийн шалгууртай холбоотой байгууллагын байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэх заагчийг тогтоох ойн удирдлагад ашигтай нэмэлт мэдээллээр хангана. ISO 14031-тай тохирох эсэх нь ISO 14001-д тавигдах шаардлага биш.

ISO 14031 нь дараахь 3 нөхцөлд БОНБГҮ-ний заагчийг тогтооно: Удирдлагын гүйцэтгэл, ажиллагаа болон байгаль орчны нөхцөл байдал. Ойн аж ахуйн байгууллагад хэрэгжүүлэх ISO 14001 стандартад байгаль орчны ач холбогдолтой асуудлыг эдгээр 3-н нөхцөлд ашиглах заагчийг хэрэглэнэ. Эдгээрийг В хавсралтанд тайлбарласан санаачлагын хэсэгт заасан заагч болон тэдгээрийн эзэмшлийн заагчийг ашиглан хийнэ. Байгаль орчны чухал асуудлыг хянахад ашиглах зарим заагчийн жишээг доор үзүүлэв.

- a) Удирдлагын гүйцэтгэлийн заагч:
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлтэй холбоотой үйл ажиллагааны зардал (хөрөнгө болон ажиллагаа)
 - Байгалийн хөтөлбөр бүхий байршлын тоо болон судалгаа
 - Янз бүрийн байрлал болон төлөвлөсөн газрын ойн нөхцөл байдалд гарах өөрчлөлт
- b) Үйл ажиллагааны гүйцэтгэлийн заагч:
 - бүтээгдэхүүн бэлтгэх зорилгоор ашигласан нийт хөрсний талбай
 - нэгж бүтээгдэхүүнд ашигласан эрчим хүчний хэмжээ.
 - Ургацын өсөлт

с) Байгаль орчны нөхцөл байдлын заагч

- орон нутагт бий болгосон онцгой зүйлийн чанарын тухай арга хэмжээ
- тусгай нутгийн түлхүүр заагч болох шувуудын зарим онцгой зүйлд зориулсан үүр
- голын булингартай урсгал

Эдгээр заагчийг зөвхөн үзүүлэнгийн зорилгоор ашиглав. Бусад бүх асуудал, заагчийг ойн аж ахуйн байгууллагад хэрэгжүүлнэ.

5.6.2. Байгаль орчны удирдлагын тогтолцооны аудит

ISO 14001 нь байгууллагын БОУТ-нд үе үе аудит хийх журмыг тогтоож, тодорхойлж байхыг шаарддаг (ISO 14001:1996, 4.5.4). Аудит нь байгаль орчны удирдлагын тогтолцоо стандарт, төлөвлөсөн зөвшөөрөлтэй нийцэж байгаа эсэхийг, ойн удирдлагын үүрэг зорилгоо хэр биелүүлж байгаа, биелэх боломжтой эсэхийг тодорхойлно.

БОУТ-ны аудитын үйл ажиллагаа нь ерөнхийдөө БОУТ-ны зорилгод хүрч байгаа эсэхийг тодорхойлох байгууллагын хяналтын мэдээллийн шалгалтыг агуулна.

ISO 14010, ISO 14011 ба ISO 14012 Байгаль орчны аудитын заавар нь ойн аж ахуйн байгууллагын БОУТ-ны аудитын хөтөлбөрт тохирсон зарчим, журам, аудиторын үр чадварыг тогтооход туслаж, дэмжих зорилгоор хэрэглэх заалтыг гаргадаг. Гэсэн хэдий ч, ISO 14001 стандартад тэдгээрийн хэрэглээг тусгайлан заагаагүй.

5.7. Удирдлагын дүн шинжилгээ

ISO 14001 нь байгууллагын БОУТ-ны тохиромжтой, үр ашигтай байдалд баталгаа өгөхийн тулд дүн шинжилгээ хийхийг шаарддаг (ISO 14001:1996, 4.6). Үүнээс гадна ойн аж ахуйн байгууллага нь хуулийн өөрчлөлт, нийгмийн болон технологийн дэвшил, шинжлэх ухаан технологийн дэвшил, сонирхогч талуудын үзэл бодол, итгэл найдварын өөрчлөлтийг хянах хэрэгтэй.

6. Ойн бага хэмжээний аж ахуйн эзэмшил, ажиллагаа

Дэлхий дээр ойн бага хэмжээний аж ахуй эрхлэгчид 10 сая гаруй байдаг. Тэдгээр нь нийгэм, эдийн засаг, экологи, модны нөөц болон ойн бусад асуудалд чухал ач холбогдолтой байна. Зарим оронд тэдгээр нь ОТХУ-ын асуудалтай бараг холбоогүй, зөвхөн хөрсөнд үр нөлөөтэй байна. Энэ нь тэдний БОУТ-нд аудит явуулах, хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд гарах хөрөнгө

мөнгөөр хангах, эсвэл хувийн аж ахуйд баталгаажуулалт явуулах арга замыг хайхад боломжтой биш байна. "Байгууллага" гэсэн тодорхойлолт (ISO 14001:1996, 3.12) нь ОАА-н ажиллагааны төрөл, хэмжээний хамрах хүрээтэй нийцнэ. Нэмж хэлэхэд, БОУТ-ны ISO 14001-д үзүүлсэн шаардлага нь ерөнхийдөө зөвлөмжийн байна. Энэ нь БОУТ-ны зөвхөн ганц төрөл, нарийвчлан нийт хэмжээг үзүүлэхгүй ба баримтжуулалтын түвшинг шаардах болно. БОУТ-той байгууллага өөрийн үйл ажиллагааг байгаль болон ажиллагааны хэмжээнд ашиглаж болно.

Шаардагдах үр дүнд хүрэхэд бага хэмжээний ой эзэмшигчид нь бүлэглэлүүдтэй хамтран ISO 14001-ыг хэрэгжүүлэх ажиллагааг сонгож болно. Олон салбарт бүлэглэлийн хэмжээ, хэлбэр нөлөөлнө, жишээ нь: удирдлага, экологийн хүчин зүйл, олон нийтийн байгууллага, хөрс. Гэсэн хэдий ч, ISO 14001:1996, 3.12, -д зааснаар зохион байгуулалтын нэгж нь эзэмших ажиллагаа, удирдлагатай байна.

Бага хэмжээний ой эзэмшигчдийн бүлэглэлийн жишээг G, H, I хавсралтаар үзүүлсэн.

7. Ойн аж ахуйн БОУТ-ны өөрийн зарласан мэдүүлэг, хоёр дахь талын аудит, хөндлөнгийн баталгаажуулалт

Ойн аж ахуйн байгууллага ISO 14001-ын өөрийн зарласан мэдүүлэг, хоёр талын аудит, хөндлөнгийн баталгаажуулалтыг сонгох ба БОУТ-г үр дүнтэй хэрэгжүүлнэ. Байгууллагын болон хэрэглэгчдийн хэрэгцээнээс шалтгаалан алийг нь сонгох вэ гэдгийг ашиглана. Өөрийн зарласан мэдүүлэг нь ISO 14001-д нийцэх дотоод шийдвэрийг мөрдөнө. Хоёр дахь талын аудитыг байгууллагатай харилцаа холбоотой гэрээлэгчийн хэсэг хийж гүйцэтгэнэ, жишээ нь: ойн бүтээгдэхүүнийг худалдан авагч, ОАА-н худалдааны нийгэмлэг, эсвэл ой эзэмшигчдийн хоорондын харилцаа.

Баталгаажуулалт нь БОУТ-ны 3 дахь талын аудиттай холбоотой байхыг шаардана. ISO 14001-ын 3 дахь талын аудит, эсвэл дотоод үнэлгээ нь Төлөвлө-Хий-Шалга-Арга хэмжээ ав гэсэн ажиллагааны дагуу явагдах бөгөөд бүхий л хугацаанд БОУТ-г сайжруулахад тусална. Баталгаажуулалтыг 3 дахь талын итгэмжлэгдсэн байгууллага явуулна.

БОУТ-той ОАА-н байгууллага 3 дахь талын баталгаажуулалт явуулах ажиллагааг мэддэг байх хэрэгтэй. Баталгаажуулалтын байгууллага нь тухай байгууллага ISO 14001-ын шаардлагатай нийцэж буй эсэхийг батлаж, дахин үнэлгээ явуулах, хянаж шалгах ажлыг гүйцэтгэнэ.

ISO 14001-ыг хэрэглэх ОАА-н байгууллага, БОУТ-ны баталгаажуулалтад өртөг зардал шаардагдана. Өртөг зардал нь ISO 14001-ын бүх

шаардлагад нийцэх БОУТ, түүнчлэн аудит, баталгаажуулалтын журмыг тогтооход хамаатай байна. Ойн аж ахуйн байгууллага ISO 14001-ыг хэрхэн яаж хэрэглэх чиг хандлагаа тодорхойлно. (байгаль орчны удирдлагыг сайжруулах, сонирхогч талуудтай харилцах, ажиллагсадын хөдөлгөөн, гэрээт үйлчилгээг сайжруулах). Энэ нь байгууллагад өөрийн зарласан мэдүүлэг, хоёр дахь талын аудит, баталгаажуулалтыг илүү их ашиглахад тусална.

8. Харилцан мэдээлэх

ISO 9000, ISO 14000 баталгаажуулалтыг сурталчлах ISO brochure сэтгүүлд ISO 14001 БОУТ-ны баталгаажуулалтын үндсэн шаардлага, харилцан мэдээлэх асуудлыг үзүүлдэг (A.5 хавсралтыг үз).

Нэмэлт мэдээлэл, хяналтыг Үндэсний итгэмжлэлийн байгууллага, Үндэсний хэрэглэгчдийг хамгаалах хууль, тогтоомж шийдвэрлэнэ. Дээрх тайлбарт нийцэх байгууллага ISO 14001 БОУТ-ны баталгаажуулалтад үндэслэсэн ашиггүй, хангалтгүй шаардлагыг анхаарахгүй байх хэрэгтэй.

Нэмж хэлэхэд, ОАА-н байгууллага өөрийн байгаль орчны гүйцэтгэлийн талаар гадна талд харилцан мэдээлэхийг хүсэж болно. ISO 14031-д үзүүлсэн байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл явц нь байгаль орчны тайланг хэрэгжүүлэх эсвэл бусад гадаад оролцогчидтой харилцан мэдээлж, мэдээллээр хангана.

А Хавсралт
(Мэдээллийн шинжтэй)

**ISO 14000 бүлэг стандартын шаардлага ба
хамаарах бичиг баримтын тойм**

A.1. ISO 14001:1996, Байгаль орчны аудитын заавар – Ерөнхий зарчим

A.1.1. Танилцуулгын хэсэг

Байгаль орчны аудит нь байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад туслах ба батлах чухал баримт бичгийг тогтооно.

Олон улсын энэ стандарт нь байгууллага, аудитор, тэдгээрийн үйлчлүүлэгчдэд байгаль орчны аудитыг явуулахад холбоотой ерөнхий зарчмийн талаар зааварлана. Энэ нь байгаль орчны аудит, хамаарах нэр томъёо, байгаль орчны аудитын ерөнхий зарчмийн тодорхойлолтыг хангаж өгнө.

A.1.2. Хамрах хүрээ

Олон улсын энэ стандарт нь байгаль орчны аудитын бүхий л төрөлд хэрэгжүүлэх байгаль орчны аудитын зарчмийн ерөнхий шаардлагыг үзүүлнэ.

A.2. ISO 14011:1996, Байгаль орчны аудитын заавар – Аудитын зарчим- Байгаль орчны удирдлагын тогтолцооны аудит

A.2.1. Танилцуулгын хэсэг

Олон улсын энэ стандарт нь байгаль орчны удирдлагын тогтолцооны аудит явуулах журмаар хангана. Энэ нь байгууллагын бүхий л төрөл хэмжээнд байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

A.2.2. Хамрах хүрээ

Олон улсын энэ стандарт нь байгаль орчны удирдлагын тогтолцооны шалгууртай нийцэх БОУТ-ны аудит явуулах, төлөвлөх аудитын журмыг тогтооно.

A.3. ISO 14012:1996, Байгаль орчны аудитын заавар – Байгаль орчны аудитын мэргэшлийн шалгуур

A.3.1. Танилцуулгын хэсэг

Олон улсын энэ стандартын зорилго нь байгаль орчны аудиторын

мэргэшлийн шалгуур заавраар хангана. Дотоод аудит нь гадаад аудит шиг эрх мэдэлтэй байх боловч олон улсын энэ стандартад үзүүлсэн нарийвчилсан шалгууртай холбоогүй байх ба доорх салбаруудад хамаатай байна:

- байгууллагын нөлөөлөх орчин, бүрдэл, унаган төрх, хэмжээ
- байгууллагын туршлага, шинжилгээтэй холбоотой хөгжлийн хэмжээ

A.3.2. Хамрах хүрээ

Олон улсын энэ стандарт нь байгаль орчны аудит болон тэргүүлэх аудитын мэргэшлийн шалгуур, дотоод гадаад аудитыг хамтад нь хэрэгжүүлэх заавраар хангана. Сонголтын болон хэлэлцээрийн шалгуур нь аудитын нэр томъёонд орохгүй. Эдгээр сэдвийг мэдээллийн байдлаар ISO 14011-д үзүүлсэн.

A.4. ISO/DIS 14031- Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ (БОНБГҮ)

A.4.1. Танилцуулгын хэсэг

БОНБГҮ гэдэг нь шийдвэрлэх үндсэн үйл ажиллагааны чухал, үнэн бодитой мэдээлэл бүхий удирдлагаар хангах зохион бүтээсэн удирдлагын арга хэрэгсэл, дотоод үйл явц эсвэл байгууллагын удирдлагын шалгуур.

БОУТ-той байгууллага нь байгаль орчны бодлого, зорилго, экологийн төлөвлөгөөт үзүүлэлт, бусад БОНБГ-ын шалгууртай холбоотой БОНБГ-ийг үнэлнэ. БОУТ-гүй байгууллага нь БОНБГ-г хэрэглэснээр түүний шалгууртай холбоотой БОНБГ-ыг үнэлэх, БОНБГ-ийн чухал шалгуурыг шийдвэрлэх, байгаль орчны асуудлыг тогтооход тусална.

БОНБГҮ, байгаль орчны аудит нь БОНБГ-ийн статусыг үнэлэх, сайжруулахад хэрэгцээт талбайг тогтооход байгууллагын удирдлагад тусална. БОНБГҮ нь гүйцэтгэлийн үнэлгээний явцыг хангах мэдээлэл, өгөгдлийг үнэлж, цуглуулахад хийгдэх үйл явц байх бөгөөд түүнчлэн бүх хугацаанд чиглэнэ.

A.4.2. Хамрах хүрээ

Олон улсын энэ стандарт нь байгууллагад БОНБГҮ-г ашиглах, бий болгох талаар заавар өгнө. Аливаа байгууллага олон улсын энэ стандартыг ашиглаж болно. Олон улсын энэ стандарт нь БОНБГ-ийн түвшинг тогтоохгүй. Үүнийг баталгаажуулалт, бүртгэлийн зорилгоор болон бусад БОУТ-нд нийцэх шаардлагыг тогтооход хэрэглэхгүй.

A.5. Өөрийн ISO 9000, ISO 14000-ын баталгаажуулалтыг сурталчлах

ISO 14000-ын баталгаажуулалтад хүрэхийн тулд цаг хугацаа, энерги, мөнгө зарцуулсан бизнесийн болон бусад байгууллага түүнд хүрснээ сурталчлахыг хүсдэг. ОУСБ-ын ISO 9000, ISO 14000-ын баталгаажуулалтыг сурталчлах сэтгүүл 1997 онд хэвлэгдсэн ба энэ нь ISO 14000-ын гэрчилгээ эзэмшигчдэд сурталчилгааны буруу, төөрөгдүүлэх, будилуулах шаардлагаас зайлсхийх, түүнд туслах материал, видео агуулсан болон ISO 14001-ыг баталсан, үнэлсэн БОУТ-г явуулах зах зээлийг зөвшөөрөх бусад арга хэрэгсэлд тусална.

Сануулах хэдэн чухал зүйл байна: ОУСБ нь ISO 14001-д тохирохыг батлахдаа БОУТ-ны аудит хийх эсвэл түүнийг үнэлэхгүй, ISO 14000-ын гэрчилгээг дүгнэхгүй, ISO 14001-ын баталгаажуулалтын зөвшөөрлийг явуулахгүй ба ОУСБ-д хамааралтай гишүүн байгууллага баталгаажуулалтыг гүйцэтгэнэ. ISO 14001 нь "ногоон", "байгаль орчинтой холбоотой" бүтээгдэхүүнд чухал эко-тэмдэг болохгүй. Бүтээгдэхүүний эко-тэмдэггүй бол сурталчилгаа, бусад туслах материалд энэ бүтээгдэхүүн нь "ОУСБ-баталсан" "ОУСБ-бүртгэсэн" гэж бичиж болно.

Хамаарах баримт бичиг:

ОУСБ-ын төв нарийн бичгийн дарга нарын газар
1, rue de Varembe
Шуудангийн хаяг 56
CH-1211 Женев 20
Швейцарь

Үндэсний стандартын байгууллага.